

МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2021 оны 07 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 2/647

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

М. Доржсанг

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Ц.МӨНХБАТ ТАНАА

*Дүгнэлт, зөвлөмжид
хангалт ажлаар*

М. Доржсанг
2021/07/27

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай


Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу аймаг, нийслэлийн 2020 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанд танилцуулсан бөгөөд хуралдаанаас гарсан 34 дүгээр тэмдэглэл болон аймаг, нийслэлийн үйл ажиллагааг дүгнэсэн үзүүлэлт тус бүрийн дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна.

Тэмдэглэл, дүгнэлт, зөвлөмжид үндэслэн төлөвлөгөө гарган ажиллаж удаашралтай, хэрэгжилт хангалтгүй байгаа ажлуудыг анхаарч зорилтот түвшин болон тодорхой үр дүнд хүргэж ажиллана уу.

Хавсралт ...16... хуудас.

ХШУДАХАА Г. Сэнгэнчорой

Зөвлөмжийг хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
Ц. Доржсанг
2021/07/27



Э.БАТ-ИДЭР

000021603236

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮД, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлд:

"ҮIII.7. Яам болон аймаг, нийслэлийн 2020 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. 2020 оны үйл ажиллагааны үр дүнгээр өндөр үнэлгээ авсан Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Дархан-Уул, Өвөрхангай, Төв, Ховд, Сэлэнгэ аймагт тус бүрд 20.0 (хорин) сая төгрөгөөр, эдгээр яамдын Төрийн нарийн бичгийн дарга нар болон аймгийн Засаг даргын Тамгын газрын даргыг тус бүр нэг сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгохыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдоржид зөвшөөрөв.

2. Үйл ажиллагааны дүнгээр доогуур үнэлгээ авсан яам, аймаг гарсан алдаа дутагдлыг засах талаар тодорхой ажил зохион байгуулж, хяналт, шалгалт хийн дүгнэлт гаргаж үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэн гүйцэтгэлийг эргэн тайлагнахыг холбогдох сайд, Засаг дарга нарт үүрэг болгов.

3. Бодлогын баримт бичгийн зорилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга барил, үнэлгээг оновчтой ашиглан бодитой, үр-дүнтэй ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**ДУНДГОВЬ АЙМГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН
ХЭРЭГЖИЛТ БОЛОН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН
2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР
2021 ОН**

НЭГ. ЗОРИЛГО

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлтүүдэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу аймгийн 2020 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах баримт бичгүүдийг хамруулсан. Үүнд:

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;
- Аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт;
- Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт.

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох:

- Засгийн газрын гишүүн аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт;
- Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт;
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт.

Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох:

- Байгууллагын ил тод байдлын үнэлгээ;
- Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ зэрэг 10 үзүүлэлтүүдийг хамруулсан болно.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2, 6.3 –т заасан арга зүйгээр дээрх 10 үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тухайн ирүүлсэн тайлангаас гадна холбогдох нэгж, байгууллагаас нэмэлт тодруулага авах, хамааралтай баримт бичиг болон статистик мэдээлэл, бусад байгууллагаас хийгддэг судалгааны дүнтэй харьцуулалт хийсэн болно. Мөн 2019 онд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг харгалзан үзлээ.

Журамд заасны дагуу нэгдсэн үнэлгээг тооцохдоо бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох 4 үзүүлэлт нийт үнэлгээний 60 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох 2 үзүүлэлт 20 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох 4 үзүүлэлтийг 20 хувиар тус тус тооцсон. Эдгээр үзүүлэлтээс шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг Сангийн яамнаас шууд авч ашигласан болно.

ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, дүгнэлт:

Тус аймаг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажилд ач холбогдолтой хандаж, өгсөн дүгнэлт, зөвлөмж, сургалтаар олгогдсон мэдлэг, арга зүйг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажилласан байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2020 оны жилийн эцсийн тайланг Засаг даргын зөвлөлийн хурлаар танилцуулсан тэмдэглэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулгын хамт тогтоосон хугацаанд ирүүлсэн. 2020 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан /unelgee.gov.mn/-д байршуулсан 71 шийдвэрийн 149 заалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн нь 89.35 хувиар үнэлэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2.16 функтээр буурсан байна.

	Хяналт	Мунхууль	Тогтоол	ҮНХ-ийн бодлогын хэрэгжилт тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ийн тогтоол	ЗС-ийн зуралдааны тэмдэглэл	ЗГ-ийн арга-азаар	Боломж, зориулалт	ХАБЗ-ийн мөрдөлийн	ХАБЗ-ийн хэрэгжилт	Эрх зүйн байгууллагын үнэлгээ
Хяналтад асан-нийт шалтгааны тоо	71	7	-	3	2	47	4	8	-	3	-	-
Хяналтад асан-нийт үйл ажиллагааны тоо	14	13	-	4	11	7	1	1	-	-	-	-
Бүрэн хэрэгжсэн	100%	100%	-	100%	-	65	-	-	-	-	-	-
Хэрэгжих шаардлага	79%	79%	-	-	-	1	-	-	-	-	-	-
Хэрэгжилт хангалтгүй	0%	0%	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хэрэгжээгүй	0%	0%	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хэрэгжилтийг туслах хувьцаа болсонгүй	Хуульдаа болсонгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Билэгтийн дундаж	89.35	81.95%	-	92.5%	92.5%	53.04%	49.17%	78.33%	100%	100%	-	-

Тодорхой шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй заалтуудын шалтгааныг тодорхойлж цаашид авах арга хэмжээний талаарх саналыг хэлэлцэн шийдвэрлэж байх асуудалд илүү ахиц гаргах.

Удаашралтай, тасарсан заалтуудын тоо өмнөх онуудтай харьцуулахад буурсан ч хэрэгжилтийн явцыг бус үр дүнг чухалчилж тайлагнах байдалд илүү ахиц гаргах шаардлага байгаа нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тайлангийн үнэлгээ, үр дүнгээс харагдаж байна.

ЗГХЭГ-аас 2019 оны жилийн эцсийн тайланд хийсэн дүгнэлт зөвлөмжтэй танилцан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг дараагийн тайлангийн танилцуулгад тусгаж ирүүлж байх гэсэн ажлыг маш сайн хэрэгжүүлсэн гэж үзэв.

Дараах заалтыг эрчимжүүлж ажиллах шаардлагатай.

МУ-ын хууль

1	2017.02.01. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/	18.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	АИТХ-ын 2017 оны тогтоолоор Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах Түр хамгаалах байрыг байгуулах, үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх тухай тогтоол гарч, Аймгийн Засаг дарга 2017-2020 онд Түр хамгаалах байрны үйл ажиллагааны зардалд 8,7 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэж өгсөн. Мөн ГБХУС чиглэлээр жил бүрийн ажлыг Аймгийн ГХУССЗ-ийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж ажиллалаа.	30% 30%
ҮАБЗ-ийн зөвлөмж				
2	2019_60/40. Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай	2.4. Томоохон голууд дээр усыг хуримтлуулан урсацын тохируулга хийх. усан сан байгуулах, нийт нутгийн хэмжээнд хур тундасны усыг тогтоон барих далан, шингээх худаг, нэвчүүлэн цөөрөм барих ажлыг эрчимжүүлэх замаар усны нөөцийгш нэмэгдүүлж,и хүн ам болон эдийн засгийн салбаруудыг баталгаатай, хүрэлцээтэй усаар хангах нөхцөлийг бүрдүүлэх	БОАЖГ Орхон голоос эх авч Онги голын урсацыг нэмэгдүүлэн Улаан нуурыг тэтгэж, улмаар говийн бүсийн сум суурингийн хүн ам, бэлчээр, хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэлийн ус хангамжийн найдвартай эх үүсвэр бий болгох, эрчим хүч үйлдвэрлэх зорилготой “Орхон-Онги” эко төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байна. Тус төслийн ТЭЗҮ-ийг “Хайдродизайн прожект” ХХК, “Престиж инженеринг” ХХК, “Монхидро констракшн” ХХК, “Жемр” ХХК-иуд хамтран гүйцэтгэж байна.	30% 30%
3		2.7. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвлүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих	БОАЖГ “Онгийн нууц”, “Онги энерги”, “Говь суварга” жуулчны баазууд ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулж цэвэршүүлсэн саарал усыг ногоон байгууламжийн усалгаанд дахин ашиглаж байна. Баяжуулах үйлдвэртэй Гурвансайхан, Баянжаргалан сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Эрдэнэс силвер ресурс” ХХК, “Болор жонш” ХХК-уудад үйлдвэрлэлийн хаягдал	30% 30%

4	2.11. Хо, суурин газрын үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах системийн найдвартай ажиллагааг хангах	<p>бохир усыг дэвшилтэт технологи нэвтрүүлж дахин ашиглах тухай зөвлөмж өгөв.</p> <p>Мандалговь хотын инженерийн бэлтгэл арга хэмжээнд 6,5 тэрбум төгрөгийн өртөг бүхий 7,68 км үерийн хамгаалалтын далан суваг шаардлагатай байгаа бөгөөд Барилга, хот байгуулалтын сайдын багцад 1,424 тэрбум төгрөг батлагдаж барилга угсралтын ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр “Химон констракшн” ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулж эхний ээлжийн 1,2 км далд сувгийн ажлыг гүйцэтгэж 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүлээлгэн өгсөн. Үерийн хамгаалалтын далан сувгийг бүрэн дуусгахад 5,1 тэрбум төгрөгийг 2020, 2021 оны улсын төсөв болон Азийн хөгжлийн банкны хөрөнгөнд тусгахаар санал хүргүүлсэн боловч хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй болно</p>	30% 30%	
ЗГ-ын тогтоол				
5	2019_183. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	3. Салбар бүлэг болон зуны цэцэрлэг ажиллуулах мэргэжлийн багш, хүний нөөцийг бэлтгэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	<p>БСУГ БШУСайдын тушаалаар ажлын хэсэг байгуулан, туслах багш нарыг мэргэшүүлэх, хувилбарт сургалтын бүлгийн багш бэлтгэх сургалтыг зохион байгуулах сургалтын нэгдсэн хөтөлбөрийг боловсруулж байна. Аймгийн хэмжээнд мэргэжлийн цэцэрлэгийн багш, туслах багшийн хүний нөөцийн судгааг авч санг бүрдүүлэн ажиллаж байна. Аймгийн МСҮТ-ийн ангид 2 туслах багшийг бэлтгэн төгсгөсөн. Нөөцөд энэ оны байдлаар туслах багш 3 байна</p>	30% 30%
6	2020_144. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг	1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг	<p>1. Аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/289 дугаартай захирамжаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.</p>	30% 30%

	<p>тоолууржуулах тухай хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай.</p>	<p>Дулааны тоолууржуулах барилга байгууламжийн судалгааг гарган тоолуур зардаг 2 байгууллагаас үнийн судалгааг гаргаж байна.</p>
	<p>ЗГ-ын хуралдааны тэмдэглэл</p>	
<p>7</p>	<p>2020_26. 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр 26 дүгээр тэмдэглэл</p>	<p>ҮII.. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгох; 2. Дулааны тоолуур худалдан авах, суурилуулахад шаардагдах хөрөнгийг төсөвт байгууллагын зарлагын хэмнэлт, давсан орлогоос холбогдох хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлэхийг Төсвийн захирагч нарт зөвшөөрөх;</p> <p>Аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/289 дугаартай захирамжаар ажлын хэсэг байгуулан дулааны тоолууржуулах барилга байгууламжийн судалгааг гарган тоолуур зардаг 2 байгууллагаас үнийн судалгааг гаргаж байна.</p>
		<p>30% 30%</p>
	<p>ЗГ-ын албан даалгавар</p>	
<p>8</p>	<p>2019_03. Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай</p>	<p>3.. Албан даалгаврын хэрэгжилтийг дүгнэж, тайланг улирал бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг улирал тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд.</p> <p>2020 оны 4 сард ХХМТГ-аас ирүүлсэн чиглэл, хамтран ажиллах хүсэлтийн дагуу Төрийн үйлчилгээг цахимжуулах E-Mongolia төсөлд аймгийн 15 сум хамруулан 75,0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлэн Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал e-mongolia.mn сайтаас нэг шатлалт үйлчилгээний оператораар дамжуулан 19 төрийн байгууллагын 181 төрлийн мэдээлэл, лавлагааг 3800 иргэнд хүргэн ажлын явцыг албан даалгаврын хэрэгжилтийн 1.1, 1.2 дах заалтаар гарган 2020.12.25-</p>
		<p>30% 30%</p>

9	2020_2. Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай	1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах;	нд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээд байна. Мөн 2020 онд Аймгийн төвд байрладаг ТҮЦ машинаас 8246 иргэн мэдээлэл, лавлагаа авч үйлчлүүлсэн байна. Аймгийн хэмжээнд цахим тоон гарын үсгийг нийт 1299 татвар төлөгчид олгон татварын тайлан, тодорхойлолт авах, татварын төлөлт зэрэгт нууц үгээр баталгаажсан тоон гарын үсгийг ашиглаж байна. Аймгийн ЗДТГ-т 18, татварын байцаагч нар цахим системд ажиллахад тоон гарын үсэг ашиглаж 26, байцаагчид тоон гарын үсэг олгоод байна. Нийгмийн даатгалын хэлтсээс тоон гарын үсгийг 31 ААН-д олгоод байна. Орон нутгийн өмчийн газраас тендэрт оролцогч 75 ААН байгууллагаас тоон гарын үсэг ашиглан материал хүлээн авч ажиллаж байна. Тоон гарын үсгийг НДХ болон ОНӨГ-ийн чиглэлээр МОН-ПАСС компани 66000 төгрөгөөр худалддаг ба жилийн сунгалтын хураамж 20000 байна. Аймгийн Цагдаагийн газрын дарга болон 7 тасгийн дарга тоон гарын үсгээр тайлан мэдээг илгээж байна. Улсын бүртгэлийн хэлтсийн 3 албан хаагч ашиглаж байна.	30% 30%
10		1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах;	Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар аймгийн сайт, цахим хуудас, олон нийтэд мэдээлэл түгээж байна	30% 30%

3.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, дүгнэлт:

Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 203 дугаар тогтоолд аймаг, нийслэлийн Тамгын газар хэрэгжүүлэхээр заасан арга хэмжээнд үндэслэсэн болно.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 75.5 хувьтай гэж үнэлэв.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс хэрэгжилт нь удааширч байгаа зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллаж 2020 оны зорилтот түвшинд хүргэх, 2020-2021 онд хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн боловч шаардагдах хөрөнгө нь 2021 оны орон нутгийн болон улсын төсөвт тусгагдаагүй арга хэмжээнүүдийн судалгааг гаргаж, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх талаарх санал боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагад танилцуулан шийдвэрлүүлэхийг зөвлөж байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНЭЭС

3.7.9.8. Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулна.

3.7.12.4. Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга, байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

4.6.3.2. Орон нутгийн хамгаалалтын сургалтын тогтолцоог бүрдүүлэх, томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангана.

4.6.3.3. Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөө, даалгаврыг шинэчилнэ.

5.1.4.1. Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ.

6.2.12.1. Аймгийн төвөөс алслагдсан сумдад ажиллаж, амьдарч байгаа эрүүл мэнд, боловсрол, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагчдын ажиллаж, амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх хүрээнд албаны орон сууцаар хангах ажлыг зохион байгуулна.

6.2.13.1. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3.3. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, дүгнэлт:

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад үнэлэлт, дүгнэлт өгөх тухай Аймгийн ИТХ-д танилцуулж тодорхой үр дүнд хүрсэн буюу 83.1 хувьтай үнэлсэн байна. Тайлантай танилцаж үнэлгээ хийхдээ холбогдох журамд заасан аргачлалын дагуу үнэлэв. Дундговь аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт нь 80 хувь болж өмнөх оныхоос 9 пунктээр буурсан байна.

Ангилал	Үнэлгээ	ЗДТГ-ын үнэлгээ хийсэн арга хэмжээний тоо	ЗГХЭГ-ын үнэлгээ хийсэн арга хэмжээний тоо
Үнэлэх боломжгүй	-	0	0
Үр дүнгүй	0%	1	3
Эрчимжүүлэх шаарлагатай	40%	7	8
Эрчимжүүлэх шаарлагатай	70%	16	19
Эрчимжүүлэх шаарлагатай	100%	48	40
Эрчимжүүлэх шаарлагатай		72	70
		ЗДТГ-ын үнэлгээ	ЗГХЭГ-ын үнэлгээ
Үнэлгээ		86.11%	80.71%

Дүгнэлт

Дундговь аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй танилцаж дараах дүгнэлтийг гаргаж байна. Тухайн жилийн биелэлт өмнөх жилийн үнэлгээнээс буурсан ч тайлагнасан байдал, үнэлсэн арга зүй, хариуцсан ажилдаа жил ирэх тутам чадваржиж байгааг дурдмаар байна.

Зөвлөмж

1. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, үндсэн чиглэл хэрэгжих хугацаанд гарсан үр дүнг тайланд тусгах,
2. Хариуцсан нэгж, захиргаа удирдлагын газар\хэлтэс\-н дарга, албан хаагч нарын ажлын хариуцлагыг сайжруулах,
3. Албан хаагч нарын тогтвортой байдлыг хангаж ажиллах,
4. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өмнөх жилүүдэд хүргүүлсэн зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлж ажиллах,
5. Аймгийн ажил хариуцсан шат шатны дарга нар үндсэн чиглэлийн тайлантай бүрэн танилцах,
6. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, үндсэн чиглэлийн биелэлтийн үр дүнд аймаг, орон нутагт хийгдсэн ажлууд ард, иргэдэд хэрхэн хүрч байгаа талаар товч тайлан гаргаж аймгийн иргэдэд сурталчилан танилцуулах.


3.4. Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, дүгнэлт:

Дундговь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2021 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 1/268 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлсэн байна. Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэмдэглэл, толтоол болон Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлсэн эсэх нь тодорхойгүй албан бичгийн бүрдэл дутуу ирүүлсэн.

Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 4 жилийн өссөн дүнгийн үзүүлэлтийг **87.59 хувьтай** үнэлэн ирүүлснийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хянан үзээд тухайн жилийн хэрэгжилтийг тооцож **86.26 хувийн** биелэлттэй гэж үнэлэв.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувь, үнэлгээ:

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт



Дундговь аймгийн хэмжээнд 7 дэд хөтөлбөр батлуулан хэрэгжүүлж явцыг 86.82% хувийн хэрэгжилттэй байна.

Тайлагнасан, үнэлгээ хийгдсэн үзүүлэлтийн хэрэгжилтийн байдал:

Ангилал	Үнэлгээ	ЗДТГ-ын үнэлгээ хийсэн арга хэмжээний тоо	ЗГХЭГ-ын үнэлгээ хийсэн арга хэмжээний тоо
Үнэлэх боломжгүй	-	1	1
Үр дүнгүй	0%	9	9
Эрчимжүүлэх шаарлагатай	40%	14	16
Тодорхой үр дүнд хүрсэн	70%	26	31
Үр дүнтэй	100%	154	147
Нийт дүн		204	204

Дүгнэлт

ЗГХЭГ-аас өмнөх оны тайланд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнд өгсөн зөвлөмжид тусгагдсан ажлуудыг төлөвлөгөө гарган зарим ажлуудыг гүйцэтгэсэн хэдий ч гол чухал журамд заасан зорилт, арга хэмжээг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй харьцуулан бодитой үнэлгээ хийх боломжийг олгохгүй тайлан шаардлага хангахгүй байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 4 жилээр бүх арга хэмжээг төлөвлөн жил бүр хэрэгжилтийн явцаа тайлагнаж бодитой хийсэн ажлаа үнэн бодитой хэмжигдэхүйц нотлогдохуйцаар тайлагнаж үнэлж дүгнэх хэрэгтэй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, бодлогын баримт бичгийн уялдаа түүнийг хэрхэн яаж орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх талаар албан хаагчдыг Олон улсын байгууллагын тусламж, дэмжлэгээр чадавхжуулж байгаа аймгийн хувьд хүлээлт өндөр байсанг онцолж байна. Харамсалтай нь өмнөх жилээс ахисан үзүүлэлт төдийлөн гүйцэтгэлд харагдахгүй байлаа.

Зөвлөмж

Байгууллагын албан хаагчдын баримт бичиг боловсруулах, судалгаа, баримт, нотолгоонд тулгуурлан үнэн зөв тайлагнах ур чадварыг нэмэгдүүлэх. Тайлагналт хэт ерөнхий байгаагаас үүдэн тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр бодлогын ямар өөрчлөлт гарсан, нийгэмд үзүүлэх эерэг нөлөө зэргийг дүгнэх боломжийг хязгаарлаж байгаад анхаарах.

Шинэчлэн баталсан "Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль болон Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор баталсан "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн боловсруулах нийтлэг журам"-ыг судлан хэрэгжүүлэх.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 3 дугаар хавсралтад заасан загвараар ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлагнахад анхаарах.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас гаргасан үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ сэдэвт Цахим сургалтад нийт төрийн байгууллагын албан хаагчдыг хамруулан ур чадварыг нэмэгдүүлэх.

3.5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж:

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар баталсан аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийн дагуу Дундговь аймгийн 2020 оны гүйцэтгэлийг үнэлэхэд эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт 83.4 хувиар үнэлэгдсэн байна.

Дүгнэлт:

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийг төлөвлөхдөө аймгийн нийгэм, эдийн засгийн суурь үзүүлэлт дээр тулгуурлан тооцоо судалгаа хийж салбарын бодлоготой уялдуулан төлөвлөх ажил учир дутагдалтай байгаагаас шалтгаалан зарим үзүүлэлтүүд зорилтот болон суурь түвшинд хүрээгүй байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өмнөх жилүүдэд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Зөвлөмж:

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ суурь түвшин, хүрэх түвшинтэй харьцуулан үнэлж байх;
2. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн гүйцэтгэлийг ирүүлэхдээ мэдээллийг холбогдох эх сурвалжаас авч, үнэн бодитой тайлагнаж байх;
3. Зорилтот түвшинд хүрээгүй, суурь түвшинээс буурсан үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийж, түүний учир шалтгааныг тодорхойлж, холбогдох нэгжид дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх;
4. Цаашид төрийн захиргааны төв байгууллага болон аймгийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжтэй хамтран ажиллаж, нийгэм, эдийн засгийн төлөв байдлын талаарх албан ёсны статистик үзүүлэлтэд суурилж, салбарын бодлоготой уялдуулан эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг төлөвлөж байх.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. Засгийн газрын гишүүн аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

БОАЖ-ын сайд	Сангийн сайд	ХЗДХ-ийн сайд	ХХАХҮ-ийн сайд	БХ-ын сайд	БХБ-ын сайд	Соёлын сайд	БШУ-ын сайд	ЭТХ-ийн сайд	УУХҮ-ийн сайд	ХНХ-ын сайд	ЭХ-ний сайд	ЭМ-ийн айдс	Үнэлгээний дундаж
96.2	81.1	89.6	75.9	85.0	93.5	80.0	84.0	79.1	78.3	81.4	95.0	84.5	78.8

Засгийн газрын гишүүдтэй 2020 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг 78.8% гэж үнэлэв. Засгийн газрын гишүүнээс аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн тайланг хугацаанд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийж ирүүлсэн байна.

Зөвлөмж:

Дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг зөв төлөвлөх мөн зорилтот түвшинг ерөнхий байхаас татгалзах, тайлан тодорхой бүрэн байх, тухайн арга хэмжээ хэзээ ямар хугацаанд болсон талаар цаг хугацааг тусгах, тайлагналтыг ойлгомжтой товч тодорхой бичих, чанар тоон үзүүлэлттэй арга хэмжээг суурь түвшинтэй харьцуулан загвар аргачлалын дагуу тайлагнаж ирүүлэх. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу үнэлгээ хийж ирүүлэх.

4.2. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 86.8 хувьтай гэж дүгнэв. Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхой тайлбарлах, цаашид үргэлжүүлэх шаардлагатай арга хэмжээг дараа жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой тусгах, шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлох, хүрэх түвшинг тухайн жилдээ биелэгдэх боломжтойгоор тодорхойлох, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин хоёрыг уялдуулах шаардлагатай байна.

Мөн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа салбарын стратеги төлөвлөгөөний зорилт, арга хэмжээн дээр үндэслэн оновчтой, бодитой, тодорхой байх, бүтцийн хувьд хэт олон арга хэмжээтэйгээр хийхгүй байхад анхаарна уу.

4.3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-

шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 4 дүгээр хавсралтын дагуу Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2 зорилт, 7 үйл ажиллагааны 14 шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэв.

Зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийг тооцохдоо баталгаажуулан ирүүлсэн жилийн эцсийн хэрэгжилтийн тайлангийн чанар, хугацаанд үндэслэхийн зэрэгцээ аймаг, орон нутагт шалгалт, сургалт, семинар, албан ажлаар ажиллах үед цуглуулсан мэдээлэл, бодит нөхцөл байдал, хөндлөнгийн судалгааны дүн зэргийг харгалзан үзсэн болно.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2020 оны гүйцэтгэлийг тухайн байгууллагаас ирүүлсэн тайлан мэдээлэл, дээр дурдсан бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж **91.4 хувиар** үнэлэв.

Дүгнэлт:

Албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт зохих түвшинд хийгдэж байгаа хэдий ч сургалтын хэрэгцээ шаардлага, агуулга, сэдэв, хамрах хүрээ, оролцогчдын бүртгэл, судалгаатай холбоотой мэдээллийг тайланд бүрэн тусгах, цар тахал бүхий үед зайны буюу цахим сургалтыг өргөнөөр ашиглах нь зүйтэй байна. Ажилтан, албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөл, ажиллах орчны таатай нөхцөлийн талаарх санал асуулгыг зохион байгуулсан гэх боловч санал асуулга чанартай хийгдсэн эсэх, асуулгын дүнгийн мөрөөр ямар арга хэмжээ авч ажилласан тухай мэдээлэл хангалтгүй байна. Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд жил бүр хамруулах ажлыг урт хугацаанд тогтмолжуулах шаардлагатай гэж дүгнэв.

Зөвлөмж:

- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг Төрийн албаны тухай хууль болон уг хуулийг дагалдаж гарсан бусад эрх зүйн актад нийцүүлэн боловсруулж, албан хаагчдын санал, бусад оролцогч талуудын зөвлөмжийг тусган хэрэгжүүлэх,
- Дунд хугацаанд болон тухайн жилд авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнд гарсан өөрчлөлтийг хэмжих үүднээс шалгуур үзүүлэлтийн утга нь суурь түвшин болон өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөн талаарх мэдээллийг үндсэн тайланд товч, тодорхой тусгаж, холбогдох нотлох баримт, гарсан шийдвэр, бүртгэл судалгааг хавсралтаар дэлгэрэнгүй тайлагнах,
- Арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайланг нэгтгэх, хяналт-шинжилгээ хийхэд оролцож буй нэгж, албан тушаалтнууд нь удирдлага болон дээд шатны байгууллагыг бодитой мэдээллээр хангахад анхааран ажиллах,
- Шалгуур үзүүлэлт бүрийн утгыг аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээлэл болон тухайн аймгийн хэмжээний нэгдсэн мэдээлэл гэсэн байдлаар ангилан ирүүлж байх,
- Цар тахал бүхий энэ үед албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх дотоод, гадаад сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулахыг тус тус зөвлөмж болгож байна.

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

5.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-

шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9 дүгээр хавсралтад туссан "Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт"-ийг Үйл ажиллагааны ил тод байдал, Хүний нөөцийн ил тод байдал гэсэн үндсэн 2 ангиллын 14 шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэв.

Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг тооцохдоо баталгаажуулан ирүүлсэн жилийн эцсийн хэрэгжилтийн тайланд үндэслэхийн зэрэгцээ шалгалт, сургалт, семинар, албан ажлаар орон нутагт ажиллах үед цуглуулсан мэдээлэл, бодит нөхцөл байдал, хөндлөнгийн судалгааны дүн, цахим хуудас, мэдээллийн самбарын хөтлөлт зэргийг харгалзан үзсэн болно. Дундговь аймгийн цахим хуудас /dundgovi.gov.mn/ болон ил тод байдал хэсгийн мэдээлэл бүрэн бөгөөд хэвийн байв.

Байгууллагын ил тод байдлыг хангах замаар иргэд, олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангах зорилтын 2020 оны гүйцэтгэлийг тухайн байгууллагаас ирүүлсэн тайлан мэдээлэл болон дээр дурдсан бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж 84.2 хувиар үнэлэв.

Дүгнэлт:

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, 8 дугаар зүйл заасан хүний нөөцийн ил тод байдлын талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан төр засгийн мэдээлэл, үйлчилгээг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагад ойлгомжтой байдлаар, илүү хялбар, хурдан шуурхай хүргэх талаар авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний хэрэгжилт, гарсан үр дүнг тооцон үзэхэд ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт тус бүрийн хэрэгжилт харилцан адилгүй байна.

Зөвлөмж:

- Засгийн газар авлига, хүнд суртлыг таслан зогсоож, авлигын индексийг бууруулах зорилго тавин ажиллаж байгаа учир төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах талаар төлөвлөгөө гарган ажиллах,
- Бүрэн хэрэгжээгүй үзүүлэлт бүрийн хэрэгжилтийг сайжруулах, мэдээ мэдээллийн чанар, хүртээмжийг чанаржуулах талаар авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнд гарсан өөрчлөлтийг хэмжих үүднээс шалгуур үзүүлэлтийн утга нь суурь түвшин болон өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөн талаарх мэдээллийг үндсэн тайланд товч, тодорхой тусгаж, холбогдох нотлох баримт, гарсан шийдвэр, бүртгэл судалгааг хавсралтаар дэлгэрэнгүй тайлагнах,
- Цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж буй мэдээллийн "холбогдолтой", "цаг үеийн", "найдвартай байдал"-д илүү ач холбогдол өгч, иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүртээмжтэй, хэрэглэхэд хялбар байх зарчмыг баримтлан ажиллахыг тус тус зөвлөмж болгож байна.

5.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Нийт 53 ТЕЗ нарын мэдээллээс харахад, нэг төсвийн ерөнхийлөн захирагч дунджаар 107 орчим харьяа байгууллагатай ба 2020 онд нэг байгууллага дунджаар 156 удаа мэдээлэл байршуулахаас 147 орчим удаа мэдээлэл байршуулж, ТЕЗ нарын шилэн дансны хөтлөлт дунджаар **94.3%**-ийн биелэлттэй буюу шилэн дансны хуулийг ТЕЗ нар "хангалттай сайн" хэрэгжүүлж ажилласан байна. Доорх хүснэгтээс ТЕЗ тус бүрээр 2020 онд шилэн дансны цахим нэгдсэн системд байршуулсан мэдээллийн үнэлгээг үзнэ үү.

№	ТЭЗ нарын нэрс	Харьца байгууллагын тоо	Мэдээлэл оруулах дэргэмжийн тоо /1 байгууллагад дунджаар/	Мэдээлэл оруулсан дэргэмжийн тоо /1 байгууллагад дунджаар/	Үүнд		Хэрэгжилтийн хувь	Эзлэн байр
					Хугацаандаа	Хугацаа хоцроосон		
1	Архангай аймаг	171	154	143	127	16	92.8%	16
2	Баян-Өлгий аймаг	166	156	142	123	19	91.3%	17
3	Баянхонгор аймаг	189	148	141	127	14	94.8%	9
4	Булган аймаг	165	141	136	129	7	96.9%	5
5	Дархан-Уул аймаг	93	154	145	136	9	94.4%	11
6	Дорнод аймаг	163	152	148	140	8	97.2%	3
7	Дорноговь аймаг	148	151	146	142	4	96.7%	6
8	Дундговь аймаг	147	154	141	128	13	91.3%	17
9	Говь-Алтай аймаг	178	152	145	137	8	95.1%	7
10	Говьсүмбэр аймаг	50	157	148	140	8	94.6%	10
11	Завхан аймаг	199	153	145	131	14	94.6%	10
12	Орхон аймаг	83	151	147	141	6	97.1%	4
13	Өвөрхангай аймаг	215	152	137	125	12	90.3%	18
14	Өмнөговь аймаг	178	152	144	132	12	95.0%	8
15	Сүхбаатар аймаг	136	154	145	125	20	93.8%	12
16	Сэлэнгэ аймаг	210	153	137	117	20	90.0%	19
17	Төв аймаг	244	154	144	128	16	93.1%	14
18	Увс аймаг	172	153	150	131	19	98.3%	1
19	Ховд аймаг	163	153	149	135	14	97.5%	2
20	Хөвсгөл аймаг	223	150	142	134	8	94.8%	9
21	Хэнтий аймаг	192	150	140	128	12	93.6%	13
22	Улаанбаатар	624	151	141	127	14	93.0%	15
ДУНДАЖ ДҮН							94.4	

Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд бүртгэлтэй 8254 байгууллага, хуулийн этгээд буюу 5053 төсвийн байгууллага, 551 төрийн болон орон нутгийн өмчит компани, 114 төсөл, хөтөлбөр, 77 засгийн газрын тусай сан, 2459 ТББ, нөхөрлөл хоршоо, аж ахуйн нэгж, иргэн хагас, бүтэн жил, улирал, сар, тухай бүр мэдээлэл байршуулсныг төсвийн ерөнхийлөн захирагчаар ангилан авч үзэхэд хуулийн хэрэгжилт **94.4** хувьтай байна.

Зөвлөмж

Төсвийн ерөнхийлөн захирагч бүр Шилэн дансны тухай хуулийг чанд мөрдөж, тогтоосон хугацаанд нь холбогдох мэдээллийг цахим хуудсанд иж бүрэн, үнэн зөв мэдээлж, мэдээллийн ил тод байдлыг байнга хангаж ажиллах;

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоллоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 8.5-д заасны дагуу ТЭЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын нэгж Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, хэрэгжилтийг сайжруулах.